

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”
Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255003>

МАНЖ БИЧГИЙН ХЭЛНИЙ ХОЛБОХ ҮГС¹

М.Баярсайхан

Түлхүүр үг: манж бичгийн хэл, холбох үгс, уламжлалт хэл зүйн бичгүүд, онцлог шинж, ангилал.

Удиртгал

Холбох үгс нь өгүүлбэрийн гишүүд болон саланги өгүүлбэр, эхүүдийг холбож, тэдгээр нэгж хоорондын харьцааг заах хэл зүйн үүрэгтэйгээс гадна, өгүүлбэрийн олон янз байдлыг бий болгон тухайн хэлэх гэсэн санааг оновчтой, тодорхой илэрхийлэх, бичвэрийн хэмнэл, өнгө аясад нийцүүлэн найруулах боломж олгодог найруулга зүйн чухал үүрэг бүхий хэлний хэрэглүүр юм. Холбох үгс нь аливаа хэлний хэл зүйн тогтолцоон дахь тодорхой үүрэг бүхий нэгэн ай болж, түүхэн хөгжлийн явцад хөгжин шинэчлэгдэж байдгийн хувьд тусгай хэл хийгээд төрөл хэлнүүдийн хэл зүйн бүтэц, тогтолцоо, түүний онцлог ба нийтлэгийг хам болон цуваа цагийн үүднээс шинжлэн тодруулах судалгааны нэгэн оногдохуун болно.

Иймээс манж хэлний хэл зүйг цогцоор нь судлах, цаашилбал Алтайн хэлнүүдийн хүрээнд туслах үгсийн аймгийг харьцуулан судлахад манж бичгийн хэлний холбох үгсийн тогтолцоог зайлшгүй судлах шаардлагатай юм. Бичгийн хэл хөгжих тусам тухайн хэлний тогтворжсон холбох үгсийн тоо нэмэгдэж байдаг. Манж бичгийн хэлний хөгжилд монгол болон хятад бичгийн хэл их нөлөөлсөн, түүнчлэн Чин улсын үед монгол, манж албан бичгийн хэл зэргэд хөгжиж байсан тул монгол, манж хоёр бичгийн хэлний харилцаа холбоог лавшруулан судлахад манж хэлний холбох үгсийн судалгаа чухал байна.

Тус өгүүлэлд манж бичгийн хэлнээ түгээмэл тохиолддог хийгээд уламжлалт манж хэл зүйн бичгүүдэд тэмдэглэгдсэн холбох үгсийг бүртгэж, тэдгээрийн утга үүрэг, үндсэн шинжийг тодруулах үүднээс зарим ажиглалт хийснээ толилуулахыг зорив.

Манж бичгийн хэлний холбох үгсийн судалгааны тойм

Манж хэлний холбох үгсийн талаар тусгайлсан судалгааны өгүүлэл, нэг сэдэвт зохиол хараахан гараагүй боловч, манж хэлний дараах хэл зүйн бүтээлүүдэд туслах үгсийн аймгийн нэг болохынх нь хувьд их, бага хэмжээгээр дурджээ. Тухайлбал: И.Захаров (1879:312-313), П.Г. вон Мёллендорф (1892:13), Б.К.Пашков (1963:42-43), В.А.Аврорин (2000:229-231), Л.Горелова (2002:351-368), Гуаньжялү, Тун Юунгүн нар (2002:105-113), Лю Жиншянь, Жао Апин, Жао Жиньчүн нар (1997: 322-336), Жи Юунхай, Лю Жиншянь, Чюй Люшөн нар (1986:251-265), Х.Питерс (1940:377-

¹ Энэхүү бүтээлийг ШУТС-ийн “Алтайн хэлнүүдийн хэл зүйн харьцуулсан судалгаа. Туслах үгийн аймаг” сэдэвт төслийн хүрээнд бичив.

379) нар манж хэл зүйн бүтээлдээ манж бичгийн хэлний холбох үгсийг судалжээ.

Нэрт манжич, академич И.И.Захаров “Грамматика маньчжурскаго якука” бүтээлдээ манж хэлний холбоос нь өгүүлбэрүүдийн хоорондын холбоо болон өгүүлэмж хоорондын харьцааг илтгэх үгсийн аймгийн хувьд зэрэгцүүлэх, тусгаарлах, угсрах, эсрэгцүүлэх, болзох, шалтгаан заах, төгсгөж хаах, харьцуулах, багцаалах, үгүйсгэх, асуух зэрэг утгатай хэмээн 11 ангилжээ. (И.Захаров, 1879:312-313т) Мөн үүссэн байдлаар нь:

1. Язгуур холбох үг (*inu, geli, jai, eiči, damu*)

2. Үүсмэл холбох үг

а. Үйл үгээс үүссэн (*oči, ohode, očiibe, bime, be dahame, wajiha, de isiraqû, ofi*)

б. Нэр ба төлөөний үгэнд тийн ялгалын нөхцөл залгасан (*ereni, jaqade, bade, dade, dači*)

в. Дайвар үгээс холбох үг болсон (*udtu, tudtu, teile, damu*)

г. Хоёрхолбоос эсвэл өөрүгсийн наймгийн үгнийлж бүтсэн (*aiqa + bade → aiqabade, udu ofi, tere dade, tere angyala, teli aqû, te bičiibe, udu bičiibe, hono bade*) гэж хуваажээ.

И.Захаров холбоос үг хэмээн дурдсан үгс дотроо холбох үүрэггүй сул үг, баймж үгсийг оруулсан хэдий ч, манж хэлний холбох үгсийн судалгааг эхлүүлж, анх удаа утга, бүтцээр нь ангилсан нь хойшдын судалгаанд чухал хувь нэмэр болжээ.

П.Г. вон Мёллендорф “*jakade* ‘тулд’, *isitala* ‘хүртэл’, *turgunde* ‘учирт’ зэрэг зарим дагавар үгийг холбоос мэт хэрэглэхээс гадна *uthai* ‘даруй’, *damu* ‘загирхуу’ гэсэн анхдагч холбоос, *sohote* ‘тусгайлан’, *tuwame* ‘талаар’, *oci* ‘болбоос’, *ocibe* ‘боловч’, *ofi* ‘тул’ зэрэг үйлийн хэлбэр, *fonde* ‘үед’, *bade* ‘газарт’ гэх мэт нэрийн хэлбэр, *aibe ... aibe* ‘юуг ... түүнийг’ гэсэн төлөөний үгийн хэлбэр, *emgeri ... emgeri* ‘нэгэнтээ ... нэгэнтээ’ гэх мэт тооны нэрийг холбоосын үүргээр хэрэглэдэг” (Мёллендорф 1892:13) гэжээ.

Б.К.Пашков: “Манж хэлэнд бие даасан холбоос үг гэсэн үгийн аймаг байдаг эсэх нь маргаантай асуудал. Хэдийгээр манж хэл зүйн бүтээлүүдэд холбоос үгийн тухай хэсэг орсон байдаг боловч, тэдгээр нь их төлөв манж бичвэрийг европын хэлнүүд рүү орчуулах үүднээс тайлбарласан байдаг. Бидний бодлоор, манж хэлний эртний төлөв байдал нь үйлт нэр болон нөхцөл үйлийн хэлбэр өргөн хэрэглээтэй бөгөөд холбоос үг гэж байсангүй. Харин хожмын болоод өнөөгийн манж хэлэнд энгийн ба нийлмэл өгүүлбэрийн тогтолцоотой уялдан холбоос үгийн ай нэгэнтээ бий болсон байна” гэжээ. Ийнхүү манж хэлний өгүүлбэрийн тогтолцоон дахь холбох үгсийн түүхэн төлөв байдлыг тухайн хэлэнд үйлийн холбох нөхцөл давуу үүрэг, хэрэглээтэй байдаг онцлогтой холбон сонирхолтой чухаг дүгнэлт хийсэн нь манж төдийгүй монгол хэлэнд ч нэгэн адил хамаарна гэж бодож байна. Тэр бээр манж хэлний холбох үгсийг анхдагч (*гэли, чжсай, эйчи, ину*) ба үүсмэл (*эриньдэ, бичи, очибэ*) гэж ангилаад үүсмэл холбох үгсээ дотор нь:

1). Нэрийн өгөх-оршихын тийн ялгал бүхий: *тургуньдэ, чжакадэ, эриньдэ, фоньдэ, бадэ, дадэ*

2). Төлөөний үгээс үүссэн: *айбэ...айбэ, эрэни ... эрэни*

3). Үйл үгээс үүссэн: *бичибэ, очи, бимэ, очибэ, гожимэ, офи* гэж хуваажээ.

Мөн утгаар нь зэрэгцсэн:

холбох (соединительные) *гэли, бимэ, кэмуни, чжсай*

эсрэгцэх (противительные) *акучи, бимбимэ*

тусгаарлах (разделительные) *эйчи, эмбичи*

тодотгох (пояснительные) *дуйбулэчи, тэбичи*

Захирсан цагийн (временные) *фоньдэ, дадэ, эриньдэ*

шалтгааны (причинные) *тургуньдэ, бэ дахамэ, чжакадэ*

зорилгын (цели) *чжалинь, сэмэ*
харьцуулсан (сравнительные) *адали, гэсэ*
болзолт (условные) *айка, айкабадэ, бичи, очи, сэчи*
найр тавих (уступительные) *бичибэ, очибэ, сэчибэ, гожимэ*
хэмээн ангилсан байна (Пашков Б.К. 1963:42-43 т.).

В.А.Аврорин манж хэлний холбох үгийг утгаар нь зэрэгцүүлэх (сочинительный), захируулах (подчинительный) гэж хуваана гээд зэрэгцүүлэх холбох үгсэд *гэли ‘бас’, жай ‘жич’, кэмуни ‘басхүү’, дадэ ‘угтаа’, хоно ... бадэ ‘харин ч ... газарт’, даму ‘гагцхүү’, элэмаңга ‘харин ч’, нэмэмэ ‘нэмж’, аинчи ‘лав’, эичи ‘эсвээс’, эмбичи ‘эс бөгөөс’, эмэму ‘заримууд’* зэрэг үгсийг жишээ болгон дурдсан байна. Түүнчлэн захируулан холбох үгсээ:

1). Шалтгаан-үр дагаврын холбоо(причинно-следственный связь)-г илтгэх эдэ *‘үүнд’, эрэни ‘үүгээр’, эрэчи ‘үүнээс’, тэрэни ‘түүгээр’, тэрэчи ‘түүнээс’;* 2). Нөхцөлдөх харьцаа(отношение условия)-г илтгэх *айка ‘хэрвээ’, айкабадэ ‘хэрвээр’, оходэ ‘болбоос’, сэчи ‘хэмээвээс’, тэтэндэрэ ‘төдий буй за’;* 3). Цагийн харьцаа(временные отношения)-г илтгэх *утхай ‘даруй’, сака ‘сац’, маңги ‘хойно’, тэйкэ ‘мөнөө’, тэни ‘сая’;* 4). Дутагдах утгат (уступительное значение) *уду ... сэмэ/очибэ/бичибэ ‘хэдий ... хэмээвч/боловч, авч’, гожимэ ‘атал, гэвч’, бимэ ‘бөгөөтөл’, сэмэ ‘хэмээвч’, сэчибэ ‘хэмээвч’;* 5). Зэрэгцүүлэх утгат (сопоставительное значение) холбоос *ай ... ай ... ‘ямар ... ямар ...’, вэ ... вэ ... ‘хэн ... хэн...’, айбэ ... айбэ ... ‘юуг ... юуг ...’, абси ... абси ... ‘хааш ... хааш ...’, атаңги ... атаңги ... ‘хэзээ ... хэзээ ...’* гэж ангилжээ. (В.А.Аврорин, 2000: 229-231 т.)

Манж бичгийн хэлний холбох үгийг илүү дэлгэрэнгүй нарийвчлан судалсан эрдэмтэн бол Л.Горелова юм. Тэр бээр “Manchu Grammar” хэмээх бүтээлдээ “Манж хэлний бараг бүх хэл зүйн номд холбоос үгэнд зориулсан бүлэг байдаг боловч, тэдгээр нь үнэндээ Европын хэлнүүд рүү орчуулах шаардлагын үүднээс харсан байдаг. Манж хэлэнд жинхэнэ холбоос байдаггүй нь манж хэлэнд эртнээс үйлт нэр болон нөхцөл үйлийн тогтолцоо түлхүү хөгжсөн шинжтэй холбоотой гэж таамаглаж байна. Өгүүлбэр зүйн олон янзын харьцааг үйлт нэр болон нөхцөл үйлийн хэлбэрүүдээр илэрхийлж болох тул олон тооны холбоос хэрэггүй байв. Эцэстээ манж бичгийн хэлэнд нийлмэл өгүүлбэрийн түгээмэл тогтолцоог бий болгохтой уялдан холбох үгсийн ай бий болжээ” хэмээн Б.К.Пашковын саналыг дэмжээд “Гэсэн хэдий ч, холбох үгийн үүрэгтэй гэж болох олон туслах үгс нь өөр үгийн аймгаас холбох үг болох шилжилтийн байдалтай байна гэж болно. Холбоос үгийг зөв ялгахын тулд стандарт онолын шаардлагыг хангасан эсэхийг харгалзах ёстой боловч, манж хэлний холбох үг гэж үздэг үгсийн цөөхөн хэсэг нь эдгээр шаардлагыг хангадаг” гэсэн дүгнэлт хийжээ (Л.Горелова, 2002:352). Тэр бээр манж хэлний холбох үгийг бүтцээр нь үндсэн (үүсмэл бус), үүсмэл гэж хуваагаад үүсмэл бус холбоос нь *damu ‘гагцхүү’, eici ‘эсвээс’, geli ‘бас’, jai ‘жич’, uthai ‘даруй’* зэрэг анхандаа өөр үгсийн аймгийн үгс байсан боловч хувирлын (conversion) аргаар холбоос үг болжээ. *Damu, geli, jai* зэрэг нь угтаа дайвар, *uthai* нь төлөөлөх дайвар (pronominal adverb) үг, *eici ‘эсвээс’* нь оруулсан үг (parenthetical word) юм. Манж хэлний олон үгсийн нэгэн адил эдгээр үгс нь олон утгат /полисемантик/, олон үйлдэлт /полифункциональный/ шинжтэй бөгөөд хам сэдвээс хамааран өгүүлбэрт өөр өөр үүрэг гүйцэтгэдэг гэжээ (Л.Горелова, 2002:352).

Чингээд үүсмэл холбох үгсийг үүсэл, гарлаар нь дараах байдлаар ангилсан байна.

1. Нэр үгэнд өгөх оршихын тийн ялгалын нөхцөл залгаж үүссэн холбох үгс. Bade, dade, erinde, fonde, jakade /jaka ‘юм’+de “when,” “since” /, turgunde г.м.

2. Төлөөний үгээс үүссэн холбох үгс. Үүнд: ere, ai зэрэг төлөөний үгээс үүссэн үгс хамаарна. Хааяа aibe ... aibe ... “as ... as ...”, ereni ... ereni ... “hence” гэх зэргээр давтан хоршдог.

3. Төлөөлөх дайвар үгээс холбох үг болсон uttu, tuttu, damu;

4. Нөхцөл үйл үг(converb)-ээс холбох үг болсон үгс. Үүнд bi-, o- болон se- язгуураас үүссэн bime, bici, oci, ofi, bicibe, ocibe, seme, seci, secibe зэрэг үг хамаарна. Мөн daha+me бүтэцтэй үг үргэлж өмнөө заах тийн ялгал be-тэй хамт хэрэглэгддэг. Эдгээрээс bime, ofi-г эс тооцвол бусдыг нь холбоос үгэнд тохирно гэж үзэх боломжгүй.

5. bi-, o- болон se- хэмээх туслах үйл үгийн үүргээр орсон үйлт нэрс ихэвчлэн өгөх оршихын тийн ялгалын хэлбэрт холбох үгийн үүрэгтэй болсон байна. Тухайлбал: bisirede, ojorode, ohode, sehede, serede г.м хэмээн ангилжээ (Л.Горелова, 2002:352-354).

Мөн манж хэлний нийт холбох үгсийг утгаар нь зэрэгцүүлэх (coordinating) ба захируулах (subordinating) хэмээн хуваана гээд зэрэгцүүлэх холбоос нь өгүүлбэр зүйн адил тэгш үүрэгтэй, зэргэд нэгжүүдийг холбодог бөгөөд 1. Хамсуулан зэрэгцүүлэх (copulative/connective/), 2. Эсрэгцүүлэх (adversative), 3. Ялгах (disjunctive) гэж хувааж болно. 1. Хамсуулан холбох үгсийн гол үүрэг нь утгын хувьд адил нэгжийг холбох явдал юм. geli, jai, hono bade ‘бас’, kemuni нь ихэвчлэн хамтатгах холбоосын үүргээр хэрэглэгдэнэ. Түүнчлэн bime, dade, sere anggala, teile aku нь мөн хамтатгах утга илтгэнэ. Холбоосын утгаар хэрэглэвэл uthai “дараа нь, тэгвэл” гэсэн нэгтгэх утга илтгэнэ. 2. Эсрэгцүүлэн холбох үгс нь өгүүлбэрийн нэгжүүдийг эсрэгцүүлэн холбох гол үүрэгтэй. Үүнд: bai “харин”, akûci “эс бөгөөс”, bimbime “гэсэн хэдий ч” г.м 3. Ялган холбох үгс нь өгүүлбэрийн нэгжүүдийн хоорондын хамаарлыг илэрхийлэхэд хэрэглэгддэг бөгөөд тэдгээрийн хооронд сонголт хийх боломжийг олгодог бөгөөд eici “or/эсхүл”, eici ...eici ... “either ...or /эсвэл ... үгүй бол”, embici “or /эс бөгөөс/” г.м холбоос хамаарна. Түүнчлэн эхний нэгжийг дараагийн нэгжээр тайлбарлах юм уу тодотгохын тулд холбодог холбох үгсийн өөр нэгэн төрөл бий. Жишээ нь: duibuleci “адилтгаваас”, tebici “namely /тухайлбал/” хэмээжээ. (Л.Горелова, 2002:356-357).

Харин захируулах холбоос гэснийгээ 1. Цаг хугацааны харьцаа илтгэх (temporal) bade ‘тохиолдолд’, ‘хэрвээ’, ‘-аас хойш’, erinde, fonde, dade; 2. Шалтгааны харьцаа илтгэх (causal) be dahame, erei jalin, jakade, ofi, turgunde; 3. Үр дагаврын харьцаа илтгэх (resultative) jalin, seme; 4. Нөхцөл байдлын харьцаа илтгэх (conditional) aika, aikabade, bici, seci, oci, uttu oci, tuttu oci; 5. Дутагдах харьцаа илтгэх (concessive) eicibe, gojime, seme, bicibe, ocibe, secibe, uttu seme, tuttu seme; 6. Төгсгөж хаах (final) ereni, uttu ofi, tuttu ofi; 7. Жиших (comparative) adali, gese, ele ... ele ..., anggala гэж хуваасан байна. (Л.Горелова, 2002:357-360).

Зарим судлаачийн тэмдэглэсэн tuwame ‘үзмэгц, үзэж’, erinde ‘цагт’, fonde ‘үед’, bai ‘’ зэрэг үгийг холбоос гэж үзэхэд эргэлзээтэй, дангаараа хэрэглэгдэхдээ үгийн сангийн утгаа гээж, туслах үгийн үүрэгтэй болсон жишээ олдохгүй байна.

Манжийн уламжлалт хэл зүйн бичиг болон толь бичгүүдэд холбох үгийг тэмдэглэсэн нь

Манж хэлний уламжлалт хэл зүйн бичиг гэж болох зохиол бүтээлүүдийг шүүн үзвэл, манж хэлний үгсийн аймгийг ангилсан зүйл байхгүй боловч, нэр, үйлийн нөхцөл, туслах үгс зэрэг их төлөв үгийн сангийн бодит утгагүй, хэл зүйн үүрэг бүхий нийлэг, задлаг хэрэглүүрийг бүхэлд нь “хоосон үсэг” (untuhun hergen), сул үг (sula gisun), сул үсэг (sula hergen), туслах аялгын үсэг (aisilara mudan i hergen) гэх мэтээр нэрийдэж, жич бүлэг зүйл болгон толилж тайлбарлах, хятад, монгол хэлээр дүйлгэн орчуулах зэргээр зохиол бүтээлд тусгаж байжээ.

Манж хэлний анхны бөгөөд суурь тайлбар толь болох 1673-1708 оны хооронд зохиогдсон “Хааны бичсэн манж үгний толь”-ийн 12-р дэвтэрт “Сул үгийн зүйл” (散語類)-ийг таван анги болгон дан, холбоо, хоршоо үг бүхий 176 толгой үгийг жишээ тайлбарын хамт толилжээ. Тэдгээр “сул үг” гэж нэрийдсэн үгсийн ихэнх нь туслах үгийн аймагт хамаарах үгс байна. Улмаар хожмын “хааны бичсэн” гэгдэх албан ёсны орчуулгын болон тайлбар толь бичгүүдэд нэмэлт, засвар оруулсаар 1790-1794 оны үед зохиосон гэж үздэг “Хааны бичсэн таван зүйлийн үсгээр хавсарсан манж үгний толь бичиг”-т “Сул үгийн зүйл”-ийг зургаан анги болгон нийт 254 толгой үг оруулжээ. Тэдгээр толгой үгсийн дотор өгүүлбэр ба өгүүлбэрийн гишүүнийг холбох үүрэгтэй хэвшсэн үгс нэлээд байна. Мөн “хааны бичсэн” толийн дагуу зүйл хувааж, асуулт хариултын хэлбэрээр үгсийн утгыг тайлбарласан, 1746 оны “Нэгийг сураад гурвыг нэвтрэх манж үгний толь бичиг” (Emu be taçifi ilan be hafukiyara manju gisun i buleku bidhe, 一學三貫清文鑑)-ийн гуравдугаар ботид “Сул үгийн зүйл”-ийг оруулж утгыг нь ойролцоо үг хэллэгээр нь тайлбарлажээ.

1730 онд Шөү Пингийн зохиосон “Манж хятад үсгийн Чин вэнь чи мэн бичиг” (Manju niqan hergen i Çing wen ki meng bidhe) хэмээх зохиолын гуравдугаар дэвтрийн “Манж бичгийн үгэнд туслах аялгын үсэг” (Manju bidhei gisun de aisilara mudan i hergen) гарчигтай хэсэгт нэр, үйлийн нөхцөлүүд, дагавар, холбоос үгс, төлөөний үг, баймж үг зэргийг хятадаар тайлбарлан жишээ оруулсан байна.

Түүнчлэн 1885 онд Шу, Лунтай хэмээгчийн зохиосон “Ze fa gioi i-i bidhe”, хятадаар清文字法舉一歌 хэмээх манж хэлний зүйн бичиг, Ваньфу нарын зохиож 1894 онд барласан “Засаж сийлсэн манж хоосон үгний тэмдэг зорилгын бичиг (Dasame foloho manju untuhun hergen-i temgetu jorin-i bidhe, 重刻清文虛字指南編) хийгээд «Зургаан явдлын яамны тогтсон үг»² (Ninggun juryan i toytoho gisun, 六部成語) хэмээх манж хятад хадмал толь бичгийн нэгэн гар бичмэл эхэд буй “Хоосон үсгийн дуу” (Untuhun hergen ucun, 清文虛子歌) хэмээх бүлэгт тус тус манж туслах үгс, түүний дотор манж бичгийн хэлний холбоос үгсийг хятадаар дүйлгэн орчуулж, заримыг нь тайлбарлан холбогдох жишээний хамт оруулжээ.

Лү Ван хэмээгчийн зохиосон, он тодорхойгүй “Манж үгийн нарийн уламжлалын бичиг” (Manju gisun-i narhun ulan-i bidhe, 清文秘傳) хэмээх нэгэн гар бичмэл дэвтэрт мөн манж хэлний “хоосон үсэг” (untuhun hergen)-т хамаарах нөхцөл, үг, хэллэгүүдийг хятад хэлээрх тайлбарлан орчуулга, жишээ дагалдуулжээ. Тус зохиолын оршилд: «Манж бичигт хоосон үсэг байх нь даруй хятад бичигт сул үг байх адил, лав манж бичиг боловч, хятад бичиг боловч, цөм хоосон үсэгт итгэж үгийг цоцмуй³. Хэрвээр хоосон үсгийг тодорхойлохгүй болбоос магад санааг үл нэвтрүүлэх» хэмээн зохиолын үндсэн зорилгыг тодорхойлжээ. Хадмал орчуулгаас нь үзвэл, хоосон үсгийг хятадаар 虛字 (xūzì), сул үгийг 有助 (zhù yǔ) гэж бичжээ.

² Чин улсын үед Түшмэлийн явдлын яам, Сангийн явдлын яам, Ёслолын явдлын яам, Цэргийн явдлын яам, Шүүх явдлын яам, Үйлдэх явдлын яамыг зургаан явдлын яам гэдэг байв.

³ цоцмуй – Аливаа юмны байдал, төлөв шинж тохирохыг цоцмуй хэмээмүй. (ХБМҮТБ, 1708:20-7а)

Манж хэл зүйн бичгүүдэд тохиолдох *untuhun hergen* ‘хоосон үсэг/хийсвэр үсэг’ гэдэг нь хятадын шу-зы (虛字, *xūzì*) хэмээх уламжлалт хэл зүйн ойлголтыг үгчлэн буулгасан үг бөгөөд аливаа эд юмс, үйл хөдлөлийг заахгүй, өгүүлбэрийн утгыг нэмж тодруулах, шалтгаан, үр дагавар, нөхцөл байдал, цагийн логик холбоосууд, өгүүлбэрийн янз бүрийн хэл зүйн харьцаа, өнгө аяс, баймж утгыг илтгэх, өгүүлбэр эхлүүлэх ба төгсгөхөд ашигладаг хэсэг хийсвэр үгсийг хэлдэг ажээ. Сонгодог хятад бичгийн хэлэнд түгээмэл хэрэглэдэг “хоосон үг” ойролцоогоор хоёр зуу орчим байдаг гэх ба тэдгээрийг европын уламжлалт хэл зүйн үүднээс авч үзвэл дайвар үг, угтвар, холбоос үг, дагавар үг, сул үг, зарим тэмдэг нэр, төлөөний нэр, аялга үгэнд хамаарах үгс багтдаг байна. Хэдийгээр тэдгээр үгийн ихэнх нь үгийн сангийн бодит утгагүй боловч, бичгийн хэлний найруулгад маш чухал үүрэг гүйцэтгэдэг, тогтсон хэм хэмжээ бүхий тул аливаа эхийг зохион бичих, албан бичгийг төлөвлөхөд “хоосон үг”-ийн учир холбогдлыг чухалчлан үзэж байв. Тиймээс хааны бичсэн зүйл хуваасан толь бичгүүдэд “Сул үгийн зүйл”-ийг оруулдаг хийгээд зургаан явдлын яамны албан хэрэг хөтлөх тогтсон үгийн толийн өмнө “хоосон үг”-ийг толилсон зэрэг нь тухайн үеийн хэрэгцээ шаардлагатай холбоотой юм.

“Манж үгийн нарийн уламжлалын бичиг” (*Manju gisun-i narhun ulan-i bidhe*, 清文秘傳)-ийн оршилд мөн «Тэр ч байтугай, энэ утга уянга, шүүмжлэлийн хууль дүрэм хэмээх нь, магадаар ... цөм хятад утга уянгын найман хэлтсийн хэмжээ хэмээхийг уг болгож, манж утга уянгын найман хэлтсийн хууль дүрмийг зохион шавь нарт сургахын тул бодсон нь болой» гэжээ. Энд дурдсан найман хэлтсийн хэмжээ гэдэг нь Хятадын сонгодог бичгийн хэлний найруулгад хэрэглэж байсан 八股文 ‘*bā gǔ wén*’ (үгчилбэл найман мөчийн өгүүлэл) гэдэг бичвэрийн бүтэц, хэв маягийг заасан уламжлалт нэр томьёо юм. Чингийн үед бичгийн хүмүүс төрийн албаны шалгалтад орж, зохион бичлэг бичихдээ тэрхүү найман бүтэц бүхий стандарт хэлбэрийг барьж, утга санааг Күнзийн сурталтай холбон Хятадын ёс суртлын сонгодог зохиолуудаас эш татах нь тогтсон заншил байжээ. Эх ба өгүүлбэрийн логик холбоос, өнгө аяс, баймж утгыг илтгэх нь чухамдаа “хоосон үг”-ийг зохистой хэрэглэнэ гэсэн үг юм. Манж нар Күнз, Мэнзийн суртлын ном зохиол, хятадын уламжлалт бичгийн хэлний ёс дүрмийг судалж манж хэлээрээ олон арван зохиол бүтээлийг гаргаж байв. Үүнийг дагалдан хятадын сонгодог бичгийн хэлнээ хэвшиж тогтсон арвин үг хэллэг манж хэлэнд хуулбар орчуулгаар нэвтэрчээ. Дээр дурдсанчлан хятад хэлний шу-зы (字, *xūzì*)-д дүйх манж хэлний “хоосон үгс”-ийг тогтоож, тольд тусган, сургалт, хэрэглээнд нэвтрүүлсэн нь манж бичгийн хэлэнд түгээмэл хэрэглэдэг холбоос үгс бүрэлдэж хэвшихэд түлхэц болсон байна. Манжийн хэл зүйн бичгүүд дэх “хоосон үсэг”, “туслах аялгын үсэг”-ийн бүрэлдэхүүнд туслах үгсээс гадна, нөхцөл, дагавар, зарим дайвар үг, тэмдэг нэр орсон байдаг нь хятад хэлний шу-зы-г шууд буулгасны нотолгоо, хятад хэлний онцлогоос шалтгаалсан зүйл гэдэг нь тодорхой ажам.

Манж хэлний уламжлалт хэл зүйн бичгүүд дотор онцгой чухалд тооцогдох нэг бүтээл бол даруй Жинзай гүн, Фүжюнь нарын 1780 онд зохиосон “Гурван зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон бичиг” юм. Тус зохиол Оршил, Арван хоёр толгой үсэг, Бүлгийн дүрмийн зүйл, Сул үгийн зүйл, Сул үсгийн зүйл, Тогтсон хэмжээний зүйл, Ээлжлэн хэрэглэх зүйл, Хувилсан дүрмийн зүйл, Монгол бичгийн тогтсон үсэг, Толь бичиг (үсэг дараалсан) гэсэн бүтэцтэй. Үүнээс манж бичгийн хэлний холбох үгэнд хамаарах хэсгийг товч дурдъя. Бүлгийн дүрмийн зүйл(*fiyelen durun-i hačin*)-д манж хэлний эх болон өгүүлбэрийн эхэнд ордог холбох үгсийг хятадаар орчуулжээ. Мөн Сул үгийн зүйл(*Sula gisun i hačin*)-д “хоосон үсэг”-т хамаарах их төлөв баймж утгат үгсийг оруулсан бол Сул үсгийн

зүйл(Sula hergen i haċin)-д “хоосон үсэг”-г хамаарах голдуу хэл зүйн харьцаа заасан үгс оржээ. Эдгээрийн аль алинд нь үгсийн хятад орчуулгыг хадсаны дотор холбоос үг цөөнгүй бий. Харин Тогтсон хэмжээний зүйл (Тоүтоho hergen i haċin)-д манж бичгийн хэлэнд зарим холбоос үгийг өмнө ба хойно нь хэл зүйн ямар хэлбэр, ямар тогтсон үгтэй хамт хэрэглэдгийг дурдсан байна. Тухайлбал:

[aiqa/aiqabade ... -ċi/-hade/-hede/-hode/ohode ... -rahû/ayoo]

(Хэрвээ/p/ ... -баас⁴/-ваас⁴/болбоос ... -уузай²/болов уу)

[-ha³,-qa³_ manggi ...]

(-сан⁴_ хойно ...)

[-mbi/-raqû/aqû _sere angyala, ...]

(-мүй²/-хгүй/үгүй_хэмээх байтугай, ...)

[-ra³_ jaqade/angyala/ongyolo/dabala/]

(-x _тулд/байтугай/урьд/-аас бус)

[dade/biċi ... bihe]

(үгтаа/аваас/байваас ... бүлгээ)

[jaqade/turgunde ... -habi/hebi]

(тулд/учирт ... -жсээ)

[udu ... -ċibe/semi]

(хэдий ... /-вч/хэмээвч)

[ainaha semi ... -raqû/ojoraqû/aqû]

(хэрхэвч бээр --- -хгүй/болохгүй/үгүй)

[aiqa ... mijangyao/semi/waqao/bio]

(хэрвээ ... үнэхээр үү/хэмээгүй юү/бус уу/буй юу)

[serengge ... -rangge/inu/qai/be]

(хэмээх нь/хэмээгч ... -x нь буюу/мөн/болой/буюу)

[sehengge ... inu/qai/erebe qai/henduhebi]

(хэмээсэн нь/хэмээгсэд ... мөн/болой/үүнийг болой/өгүүлжээ) гэх мэтээр дурджээ.

Тус зохиолын Монгол бичгийн тогтсон үг хэмээх манжаар толгойлж монголоор орчуулсан бүлэг үгийн дотор холбоос үгэнд оруулж болох 37 үг орсноос гадна, түүний дараа гарчиг тавилгүй үргэлжлүүлсэн удаах хэсэгт 25 орчим холбоос үгийг монголоор хэрхэн орчуулахыг дурджээ. Жишээлбэл: ma. ofi = мо.-ийн тул, biċibe = -г боловч, ч болов, буй боловч, авч; -ra³ jaqade = ‘-сний тулд г.м

Манж, монгол бичгийн хэлний холбох үгсийн харьцуулал

Манж хэлэнд анхдагч холбоос үг байхгүй боловч, өөр үгийн аймагт хамаарах үг холбоос үг болж хувирах, үйлийн зарим холбох нөхцөлтэй туслах үйл үг, зарим нэрийн тийн ялгалтай үгс өгүүлбэрийн гишүүд болон өгүүлбэр хоорондын харьцаа заах үүрэгтэй дан ба нийлмэл холбох үг болон хэвшиж, холбоос үгийн айг

бүрдүүлсэн бөгөөд тэдгээр нь бичгийн хэлний найруулгад тодорхой хэм хэмжээ, журамшин тогтсон хэрэглээ бүхий болжээ.

Холбоос үгс нь үгийн сангийн бодит утгагүй, бие даан өгүүлбэрийн гишүүний үүрэг гүйцэтгэхгүй, эх, өгүүлбэрүүд ба өгүүлбэрийн гишүүдийн хоорондын харьцааг зааж холбох үүрэгтэй, холбож буй үг, өгүүлбэрүүдээ зэрэгцүүлж, эсвэл захируулан холбодог зэрэг нь аливаа хэлний холбох үгийн нийтлэг үндсэн шинж юм. Харин холбоос үгсийн үүсэл гарал, бүтэц, хэрэглэгдэх байдал зэрэг нь тухайн хэлний онцлогтой байж болно. Тэгвэл тухайлсан хэлэнд онцлог байж болох тийм шинжүүд нь монгол ба манж бичгийн хэлний тухайд тун ойролцоо буюу нийтлэг ажээ.

Манж бичгийн хэлний холбоос үгс нь монгол хэлний холбоос үгийн адил бүтцийн хувьд энгийн ба нийлмэл байна. Жинзай гүн нарын хэл зүйн бичиг дэх манж хэлний нийлмэл холбоос үгийн дотор *te bičibe* ‘эдүгээ боловч’, *ereĭ jalin* ‘үүний тул’, *tereĭ jalin* ‘түүний тул’, *tudtu oči* ‘тийм болбоос’, *udtu oči* ‘ийнхүү болбоос’, *udtu oho manggi* ‘ийнхүү болсон хойно’, *udtu aqū oči* ‘ийм бус болбоос’, *absi očiibe* ‘хааш боловч’, *ai očiibe* ‘юун ч болов’, *bihe biči* ‘агсан бөгөөс’, *teile aqū* ‘төдийгүй’, *ereĭ tulgiyen* ‘үүнээс гадна’ зэрэг холбоос үг тогтсон монгол орчуулгатайгаа үгийн үндэс бүтээврээрээ үгчлэн тохирно. Мөн *tudtu seme* ‘тийн хэмээвч’, *tudtu bime* ‘тийнхүү бөгөөтөл’, *udtu bime* ‘ийнхүү бөгөөтөл’, *tudtu ohode* ‘тийнхүү болбоос’, *udtu ohode* ‘ийнхүү болбоос’, *te biči* ‘эдүгээ боловч’, *be dahame* ‘-ийн тулд’, *sere angγala* ‘хэмээх ч байтугай’, *tudtu ojoro angγala* ‘тийм болох байтугай’, *tere angγala* ‘тэр ч байтугай’, *udtu ojoro angγala* ‘ийм болох байтугай’, *tudtu ofi* ‘тиймийн тул’, *udtu ofi* ‘иймийн тул’, *udtu de* ‘ийнхүү атал’, *ainaha seme* ‘хэрхэвч бээр’ зэрэг нийлмэл холбох үг нь [төлөөний үг + туслах үйл үгийн хэлбэрээс үүссэн холбоос] гэсэн бүтцээрээ нийтлэг байна.

Жич, манж монгол толь бичгүүд хийгээд хуучны хадмал орчуулгын баримтуудаас үзвэл,

ма. -ra/-re jaqade	мо. -γsan/-gsen-u/ü tulada
ма. -me ofi	мо. -qu/kü-yin tula
ма. -i jalin	мо. -yin/-un/-ün/-u/-ü tula
ма. -ha ³ , -qa ³ manggi	мо. -γsan/-gsen-u/ü qoγin-a

хэмээн монгол хэлний “тул, тулд, хойно” зэрэг холбоос үг өмнөх үгтэйгээ ямагт харьяалахын тийн ялгалаар холбогддог (орчин цагийн монгол хэлэнд харьяалахын тийн ялгалын нөхцөлийн тэг хэлбэрээр илрэх нь бий) байхад, манж хэлэнд заавал харьяалахын тийн ялгал шаарддаггүй ажээ.

Манж болон монгол хэлний дан холбох үгсийг үг бүтэх ёсны үүднээс үүсмэл ба үүсмэл бус гэж ангилж болно. Манж хэлний үүсмэл холбох үгсийг үүсгэгч үндэс, язгуураар нь:

а). Бодит үгээс үүссэн *eiterečibe* ‘элдэвлэвч’, *turgunde* ‘учирт’, *jaqade* ‘тулд’, *bade* ‘амал’, *be dahame* ‘-ийн тулд’, *dade* ‘угтаа, -ийн дээр’;

б). Туслах үйл үгээс үүссэн *ofi* ‘тул’, *oči* ‘болбоос’, *ohode* ‘болбоос’, *očiibe* ‘боловч’, *okini* ‘болтугай’, *bime* ‘бөгөөд, бөгөөтөл’, *bičibe* ‘байвч, авч’, *biči* ‘аваас, бөгөөс’, *bihede* ‘аваас, байваас’;

в). Төлөөний үгийн э-, гэ- язгуураас үүссэн *tereĭ* ‘түүнээс’, *ereĭ* ‘үүгээр’, *ede* ‘үүнд’; *tenteke* ‘тэр мэт’, *enteke* ‘энэ мэт’;

г). Асуух төлөөний үгээс үүссэн *aiseme* ‘юунд’, *ainu* ‘юуны тул’;

д). Se- ‘гэ-, хэмээ-’ үйл үгээс үүссэн *sečibe* ‘хэмээвч’, *seme* ‘хэмээн’, *sehede* ‘хэмээвээс’, *serengge* ‘хэмээх нь’;

е). Хоёр, гурван үг нийлж хураагдсан *embiči* ‘эс бөгөөс’ [*<emu+biči*], *emembihede* ‘зарим бөгөөс’ [*<emu+emu+bihede*], *bimbime* ‘бүхий амал’ [*<bimbi+bime*], *aiqabade* ‘хэрвээр’ [*<aiqa+bade*], *aiseme* ‘юунд’ [*<ai+seme*] хэмээн 6 хэсэгт ялгаж болно.

Үүний эхний таван бүтэц нь тус хоёр хэлний үүсмэл холбох үгэнд нэгэн адил зонхилдог бол үг нийлж хураагдан холбох үг бүтсэн жишээ зөвхөн манж хэлэнд цөөвтөр тохиолдож байна. Түүнчлэн холбох үг бүтээсэн залгавар бүтээврийг авч үзвэл, нэр үндсэнд өгөх оршихын тийн ялгал; заах төлөөний үгэнд гарах ба үйлдэхийн тийн ялгал; бай-, бол- туслах үйл үгэнд болзох, дутагдах, урьдчилах нөхцөл; гэ-, хэмээ- үйл үгэнд тодотгон холбох нөхцөлүүд хийгээд нөхцөлдүүлэн холбохын зэрэгцэх, хам, урьдчилах, дутагдах, болзох нөхцөл залган холбох үг бүтээдэг нь тус хоёр хэлэнд нийтлэг үзэгдэл ажээ.

Монгол хэлний холбох үгсийг хэрэглэгдэх байдлаар нь дан ба давхар хэмээн ангилсны (Ц.Өнөрбаян, 2004:318) адил манж хэлэнд мөн давхар холбох үг цөөнгүй буй. Жишээ:

[... *hono ... bade ... -be ai hendure*]

Emu hačín hono muteraqû bade, juwe hačín be ai hendure.

‘Нэгийг харин ч үл чадах амал, хоёрыг юун өгүүлэх.’

[... *hono ... bade ... -o*]

Ketuni ačara de hono bahafi ojoraqû bade, bahafi amban obuči ombio.

‘Басхүү нийлэхэд харин ч үл болох амал, сайд болгож болно уу’

[... *-ra/re/ro angyala ... -ra/re/ro de isiraqû*]

Baita šangyafi jabčara angyala, deribure ongyolo olhošoro de isiraqû.

Үгчилбэл: ‘Хэрэг төгсөөд зэмлэх байтугай, эхлэхийн урьд болгоомжлоход үл хүрэх’.

Утгачилбал: ‘Хожимдож гэмшсэнээс эхэнд нь болгоомжлох нь дээр’.

Мөн нэг үг, нэг холбоо үгийг давтсан давхар холбох үг манж хэлэнд тохиолдоно.

Жишээ:

[... *emu derei ... emu derei ...*]

Tere niyalma emu derei tačimbi, emu derei weilembi.

Үгчилбэл: ‘Тэр хүн нэг талаар сурмуй, нэг талаар үйлдмүй’.

Утгачилбал: ‘Тэр хүн сурахын зэрэгцээ ажил хийдэг’.

[... *embiči ... embiči ...*]

Embiči Muγden de generengge, embiči Halbin de generengge, gemu sini čiha dabala.

‘Эс бөгөөс Мүгдэнд очих, эс бөгөөс Харбинд очих нь цөм чиний дур бахана’.

А.Аврорин манж хэлэнд асуух төлөөний үгийг давтаж, нэгийг нь нөхцөлдүүлэн холбох нөхцөлтэй үйлийн өмнө, нөгөөг нь дараах гол өгүүлбэрийн эхэнд хэлдэг *ai... ai... , вэ... вэ..., айбэ... айбэ..., вэбэ... вэбэ..., вэдэ... вэдэ..., аймака... аймака..., атанги... атанги..., абси... абси..., уду... уду..., элэ... элэ...* зэрэг холбоос байдгийг жишээ татан дурджээ [А.Аврорин, 2000:231т]. Тухайлбал:

Би кэмнэрэ сэчибэ сундэ ай бэ чихалачи ай бэ урунаку буки.

Үгчилбэл: ‘Би хэмнэх хэмээвч чамд юуг дурлаваас юуг өгье’.

Утгачилбал: ‘Би хэмнэхийг бодовч, чи юуг хүснэ, түүнийг өгье’.

Ийнхүү манж болон монгол бичгийн хэлний холбох үгс бүтэц, хэрэглэгдэх байдлаараа бараг адил, холбох үгийг бүтээх үндэс болон залгаврууд нь их төлөв тохирч байна.

Манж бичгийн хэлний холбох үгсийг утга үүргээр нь ангилах нь

Манж бичгийн хэлний холбох үгийг холбож буй нэгжүүдийн хоорондын харьцаагаар нь дараах байдлаар ангилж болох юм.

1. Зэрэгцүүлэн холбох үгс

1.1. Тоочин зэрэгцүүлэх: *bime, jai, kemuni bime, geli, embiçi*. зэрэг холбох үг нь тухайн тоочин зэрэгцүүлж үг, өгүүлбэрээр илрэх шинж байдал, юм, үзэгдэл хам орчинд холбогдохыг илтгэнэ. Иймд англиар copulative/connective conjunctions, оросоор соединительные союзы буюу хамтатгах, нэгтгэх холбоос гэдэг байна. Өгүүлбэрийн гишүүнийг холбосон жишээ нь:

... *etu bujan arsuhangge saiqan bime huweki sunja bočo borhoho bi*.

‘... нэгэн шугуйн сүеэлсэн нь сайхан агаад өн өтгөн, таван өнгөөр багларчээ’.

aqaçun nasaçun be getu irgebun jai foholon uçulen deri tuçibuhe.

‘хаширал гомдлоо цөм шүлэг жич богино дууллаар гаргав’

Мөн дутагдахын -*çibe* нөхцөлтэй *oçibe* ‘боловч’, *seçibe* ‘хэмээвч’, *biçiibe* ‘байвч’ зэрэг холбох үгсийг давтаж тоочин зэрэгцүүлэх утга илтгэх тохиолдол бий. Жишээ:

Menggun oçibe, damtun oçibe minde majige aisilarao.

(Мөнгө ч бай, барьцаа ч бай надад өчүүхэн тусална уу)

Өгүүлбэрийг холбосон жишээ:

Tuwaçi utai doore baqû bime doyon weihi geli saburaqû.

‘Үзвээс огт гатлах газаргүй бөгөөд олом, суман онгоц бас үл үзэгдмүй’.

Aba sarafi yabtarangge yabtambi. Geli gidalarangge gidalami.

Ав тархаж харвах нь харвана. Бас жадлах нь жадлана.

Embiçi ongyolo inenggi edun dame aya ayambi, embiçi duleke manggi tulhuşeme beikuwen ombi.

Эсвээс урьд өдөр салхилж бороошино. Эсвээс өнгөрсөн хойно бүрхээж хүйтэрнэ.

1.2. Эсрэгцүүлэх: *bimbime, yojime, aqûçi, bimbime, biçiibe, tudtu biçiibe, dabala, seçiibe, elemangga, yojime, hono ... bade ...* Жишээ:

Muten bimbime tob aqû oçi miosihon ombi.

Чадал бүхий атал, төв үгүй бол гэжүү болно.

Baturu yojime bodayon aqû

Баатар бөгөөтөл бодолгогүй.

Suweni gisun umesi giyan. Udu tudtu biçiibe yargiyan-i yûnin dolo alime muteraqû qorsombi.

(Таны үг маш зөв. Хэдий түйм боловч сэтгэл дотор тэсч чадахгүй гомдмүй.)

Beue udu taçiqû de biçiibe yûnin bidhe de aqû.

(бие нь хэдий сургуульд байвч, санаа нь бичигт үгүй)

Udu endebuku aqû seĉibe, ser sere babe olhošoraqûĉi ojoraqû.
(Хэдий алдаа дутагдалгүй хэмээвч, өчүүхэн явдлыг ч болгоомжлохгүй бол болохгүй.)

Sini beye geneki sere dabala, we simbe gene sehe.
Чи өөрөө одъё хэмээхээс бус, хэн чамайг од хэмээв.

Bidhe be hono giyangname baharaqû bade, šu fiyelen arara be ai hendure.
Үгчилбэл: Бичгийг харин ч тайлбарлаж төсөөлөхгүй газраа утга уянга бичихийг юун өгүүлэх.
Утгачилбал: Ном бичгийг тайлбарлаж чадахгүй байтал хэрхэн нийтлэл бичих билээ.

1.3. Болзож сонгох: *eiĉi* (... *eiĉi* ...), *oĉibe* ... *oĉibe*, *embiĉi* (... *embiĉi* ...). Жишээ: *ŷûsa tome sain yebken qadalame mutere taiji emte, ŷûsai ejen oĉibe meiren i janggin oĉibe emte, jalan i janggin juwete, nirui janggin duite tuĉibu.*
'хошуу тутам аруухан захирч чадах тайж нэжгээд, хошууны эзэн боловч мэйрний занги боловч нэжгээд, залны занги хошоод, сумын занги дөрвөөд гарга'

Aniyadari eiĉi emi mudan eiĉi juwe mudan hafan taqûrafi baiĉame tuwabu.
'Жил бүр эсвээс нэг удаа, эсвээс хоёр удаа түшмэл зарж байцаан үзүүл'
Saiqan jaqa bihede, eiĉi asarambio, eiĉi sain hûda-be baiĉi unĉambio.
'Сайхан юм байвал, эсвээс хадгална уу, эсвээс сайн үнээр худалдана уу'

1.4. Онцлон чухалчлах: *geli, jai, dade, udhai*. Жишээ: *Mimi jui emgeri buĉehe qai. Geli aibe hairambi. Te geli ya emi juse-de bajikini seme ten hedhe werimbi.*
Миний хөвүүн нэгэнтээ өнгөрчээ. Бас юугаа хайрламуу. Эдүгээ бас ямар хөвүүндээ амь зуугтан хэмээн эд хөрөнгөө үлдээмүй.

Sini bure basan jaĉi qomso qai. Jai majige ponggime bureo.
Чиний өгөх ацаг даанч хомс болой. Бас ахиад жаахан нэмж өгнө үү.

Aiqabade hiyoošun be ŷûnime, tondo be ongyoĉi, udhai hûturi be baime, abqa be waliyara adali.
Хэрвээр ачлалыг санаад, шударгыг умартваас, даруй буяныг эрээд тэнгэрийг гээх адил болой.

Tudtu ofi, ambasa saisa hiyoošun be yabure de, urunaqû tondo be nendembi.
Тийнхүү тул, ихэс сайчуул тахимдуугаар явахуйд, эрхбиш шударгыг урьтал болгомуй.

1.5. Тодосгох: *duibuleĉi* 'зүйрлэвээс', *tebiĉi* 'тухайлбал'. Жишээ: *Tebiĉi ubai jaydan тоо, urui alin i boso ergide banjimbi.*
'Тухайлбал, нарс мод ер уулын хэрүүд ургамуй'

1.6. Лавшруулах, ахиулах: *tere angʻala, sere angʻala, teile aqû, okini*
... *gurun-i weile-be efulehe manggi: waha seme ai tusa: tere angʻala: baitalaha manggi waraci: baitalara ongrolo kimčire-de isiraqû:*
... улсын үйлийг эвдэлсэн хойно, алавч юун тус. Тэр ч байтугай хэрэглэсэн хойно алахаас хэрэглэхийн урьд хянахад хүрэхгүй.

Tondo be ufarači beye tuysičuke ojoro teile aqû, niyaman be yûtubure de isinambi.
Шударгыг алдваас бие түгшүүртэй болох төдийгүй, эцэг эхээ гутаахад хүрнэ.

... *tumen jalan de isitala tuwakiyame yabume, ainaha seme halači ojoraqû.*
... түмэн үед хүртэл сахин явж, хэрхэвч бээр халж үл болмуй.

Niyalma ama eme be hiyoošulara be sarqû okini, ama eme i juse be yosiha yûnin be tajige yûniraqû mijangʻao. Хүн эцэг эхээ ачлахыг үл мэдэх ч болтугай, эцэг эхийн хөвүүдийг өршөөсөн санааг өчүүхэн ч үл санах үнэн үү.

1.7. Нэгтгэн тоочих: *-i jergi.* Жишээ:

Čoohai ursei gaifi yabure ayûra hajun, mičen maiqan i jergi hačın be ačibumbi.
‘Цэргийн ардын авч явах зэр зэвсэг, тогоо майхны зэрэг зүйлийг ачуулмуй’.

2. Захируулан холбох үгс:

2.1. Шалтгаан заах: *tudtu ofi, udtu ofi, jaqade, erei jalin, turgunde, ofi, be dahame.*

Жишээ:

Udtu ofi, taiši taiboo de doro erdemu bisire ʻala bedhe i gese ambasa mergen oči, bidhe i dorgi be hûwaliyambi, čooha i tulergi be horolombi.

Ийнхүү тул, тайш тайвууд ёс эрдэм бүхий гар хөлийн мэт сайд нар мэргэн болбоос, бичгээр дотоодыг найралдуулж, цэргээр гадаадыг сурдуулмуй.

Ahûn deo bahafi arara jaqade, alimbaharaqû urgunjehe.

Ах дүү уулзсаны тулд, тэсгэлгүй баясав.

Jaquade гэдэг холбох үг Нишан удганы бичигт 28 удаа тохиолдож байна. Бүгд тодотгон холбохын -ra, re, ro нөхцөлт үгийн дараа оржээ. Энэ үгийг Л.Горелова јака ‘юм’+de ‘тийн ялгалын нөхцөл’ гэсэн бүтэцтэй гэжээ. Бидний бодлоор јака ‘сац’ гэсэн үгээс үүссэн гэж үзэх нь зүйтэй санагдана.

Gisurefi toytobuha be dahame, ai gelhun aqû dasame dalhidambi.

Хэлэцэж тогтсоны тулд, ямар аймшиггүй засаж өжүүрхмуй.

Guribučibe ketuni mangʻa, erei jalin mangʻašambi.

Шилжүүлэвч басхүү бэрх, үүний тул бэрхшээмуй.

Se saydaqa turgunde tušan či naqabumbi.

Нас хөгширсөн учирт тушаалаас байлгамуй.

2.2. Нөхцөл болзол заах: *aiqa, aiqabade, oči, biči, seči, ohode, sehede.* Жишээ:

aiqa abalame tučiki seči, ahalji bahalji sebe ʻatame gene

(Хэрвээ авлаар гарсугай хэмээвээс, Ахалжи, Бахалжи нарыг авч од)

2.3. Цагийн харьцаа заах: *manggi, teni, sidende*. Жишээ:

Tob oho manggi, teni terei muten be baitalambi.
Төв болсон хойно, сая түүний чадлыг хэрэглэмүй.

Tudtu udu muten bihe seme, urunaqu tondo bihe manggi, teni šangyabumbi.
Туйнхүү хэдий чадал байлаа хэмээвч, эрхгүй шударга байсан хойно, сая төгсгөмүй.

2.4. Жишин харьцуулах: *adali, gese, ele ... ele ...* Жишээ:

doro erdemu bisire yala bedhe i gese ambasa mergen oči
'эс эрдэм бүхий гар хөл мэт сайд мэргэн болбоос'

Монгол хэлэнд зорих утга илтгэсэн төлөө, тул, тулд; тухайлах утга илтгэсэн тухай, талаар; орон зайн харьцаа илтгэх тушаа, дагуу, хүртэл зэрэг захируулан холбох үгс байдаг хэмээн судлаачид дурддаг бол манж бичгийн хэлэнд тэдгээрт дүйх холбох үгс байхгүй. Тухайлбал, ма. *funde* 'төлөө' хэмээх үг хараахан зорих холбоосын утга, үүрэггүй, төлөөнөө орлон үйлдэх үндсэн утгаараа хэрэглэгдэнэ. Жишээ: *Inu urunaqu čeni funde yertešeme alimbaharaqu seyeme yünimbi*. 'Мөн эрхгүй тэдний төлөө ичингүүрч тэсгэлгүй занан санамуй', *Abqai funde wen be selgiyembi*. 'Тэнгэрийн төлөө соёлыг тархаамуй' г.м. Мөн тул, тулд гэдэг үгс монгол хэлэнд шалтгаан заах үндсэн утгаасаа гадна, зорих утга илтгэдэг болсон бол манж бичгийн хэлний тул, тулд гэсэн утгатай *ofi, bedahame, jalin* зэрэг үгс зорих утга илтгэхгүй, зөвхөн шалтгаан заах уул утгаараа хэрэглэгдэнэ.

Манж бичгийн хэл хөгжих явцад холбох үгсийн тоо олшрон өргөжиж хэрэглээнд нэвтэрч, утга үүрэг нь хэвшин тогтоход монгол болон хятад бичгийн хэл нөлөөлсөн нь толорхой байна. Энэ нь манж бичгийн хэл анх үүсэж бүрэлдэхдээ монгол бичгийн хэлэнд тулгуурласан, нөгөөтээгүүр хятадын сонгодог бичгийн хэлнээс үлэмжхэн зохиол бүтээл орчуулсныг дагалдан хятадын уламжлалт бичгийн хэлний дүрэм дэх тогтсон хийсвэр үгсийг манж хэлээрээ буулган толилж мөрдүүлж байсантай холбоотой байна. Цаашид монгол бичгийн хэл болон манж бичгийн хэлний холбох үгсийн хэрэглээ давтамжийг түүхэн үүднээс тусгайлан харьцуулж үзсэнээр хоёр хэлний холбох үгсийн хувирал, хөгжлийн олон учир шалтгааныг тодруулах боломжтой юм.

Товчилсон үг:

ма. - манж хэл

мо. – монгол хэл

ХБМҮТБ – Хааны бичсэн манж үгний толь бичиг

Ном зүй

- Аврорин В.А. 2000. *Грамматика манжсьчжурского письменного языка*, СПб.: Наука. -243 с.
Aixingueluo Ula-Xichun, 1983. «Manju gisuni gisun doro 满语语法 (Айшин гиоро Үлхичүн, 1983.
Манж хэлний хэл зүй. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.)
Gorelova Liliya M. 2002. *Manchu Grammar*, Brill Academic Publishers. -600 p. -ISBN 9004123075
Guānjiālù, Tóng yǒng gōng, 2002. Jiǎnmíng mǎn wén wénfǎ. Shěnyáng, Liáoníng mínzú chūbǎn shè. (

- 关嘉禄, 佟永功, 2002. *Kemungge getuken manju hergen-i šuduru*. 《简明满文文法》沈阳, 辽宁民族出版社 Гуаньжялу, Тун Юунгүн нар, 2002. Манж хэлний товч хэл зүй, Шэньян.) ISBN 9787-80644-558-7. 105-113т.
- Ji Yǒnghǎi, Liú Jǐngxiàn, Qū Liùshēng, 1986. *Mǎn yǔ yǔfǎ*. Běijīng. Mǐnzú yǐnshuā chǎng, (季永海, 刘景宪, 屈六生. 《满语语法》. 北京, 民族印刷厂. Жи Юунхай, Лю Жиншянь, Чюй Люшөн, Манж хэлний хэл зүй. Бээжин, Ардын хэвлэлийн хороо.)
- Gǐng jǎi gung /敬齋/, Fugiyūn /富俊/. 178092. *Han hačín i gisun qamčibuha tuwara de ja obuha bidhe* (Жинзай гүн, Фүжюнь, Гурван зүйлийн үг хадмал үзэхүйд хялбар болгосон бичиг) Захаров И. 1879. *Грамматика маньчжурского языка*. — Санкт-Петербург: Типография Императорской Академии наук. -324 с.
- Liújǐngxiàn Zhào'āpíng Zhàojīnchún. 1997. *Mǎn yǔ yánjiū tōnglùn*. Hēilóngjiāng cháoxiān mǐnzú chūbǎn shè (刘景宪, 赵阿平, 赵金纯. 《满语研究通论》 黑龙江朝鲜民族出版社. Лю Жиншянь, Жао Апин, Жао Жиньчунь, 1997. Манж хэл судлалын ерөнхий удиртгал. Хар мөрөн мужийн солонгос үндэстний хэвлэлийн хороо.) ISBN 7-5389-0765-3. 322-336т
- von Möllendorff Paul G. 1892. *A Manchu Grammar with Analysed texts*. Shanghai: Printed at the American Presbyterian Mission Press. -53 pp.
- Ц.Өнөрбаян, 2004. Орчин цагийн монгол хэлний үг зүй. Уб.
- Пашков Б.К. 1963. Маньчжурский язык, М.: Издательство восточной литературы. -68 с.
- Han i araha manju gisun i buleku bidhe, 1780.(Хааны бичсэн манж үгний толь бичиг)

Резюме

В алтаистике актуальным является вопрос об общей типологии и особенностях синтаксиса алтайских языков, что требует тщательного сравнительного изучения союзов в языках, входящих в эту группу.

В данной статье представляем наше видение о грамматическом значении, грамматической функции и об основных признаках союзов маньчжурского языка, которые были проштудированы по тематическим словарям, грамматикам маньчжурского языка и часто встречающиеся в письменном маньчжурском языке. Поскольку в маньчжурском языке как таковых исконных союзов нет, они часто выражаются союзными словами, образованными от указательных местоимений с падежными аффиксами, деепричастиями от вспомогательных глаголов, глаголом-корнем se- (гэ-), а также союзами путём конверсии.

Грамматическая функция, грамматическое отношение, структура и употребление весьма схожи с монгольским языком. Поэтому представляется возможным классифицировать их как в монгольском языке: по словообразованию – производные и непроизводные, по структуре – простые и сложные, по значению – сочинительные и подчинительные. Общность грамматического значения и употребления союзных слов монгольского и маньчжурского языков – это результат взаимовлияния этих языков? Это вопрос дальнейших исследований.